



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



Улаанбаатар хот

2020 он



Монгол Улсын Үндэсний статистикийн хороо

ХӨДӨЛМӨРИЙН САЛБАР 2019 ОН

Улаанбаатар хот

2020 он

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

А.Ариунзаяа	ҮСХ-ны дарга
Ч.Баянчимэг	ҮСХ-ны дэд дарга
А.Амарбал	ҮСХ-ны ХАНСГ-ын дарга
Э.Гантуяа	ҮСХ-ны ХАНСГ-ын ахлах статистикч

ТАНИЛЦУУЛГЫГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

М.Доржпагам	ҮСХ-ны ХАНСГ-ын статистикч
Н.Болорчимэг	ҮСХ-ны ХАНСГ-ын статистикч
Э.Билгүүн	ҮСХ-ны ХАНСГ-ын гэрээт ажилтан
Х.Анударь	ҮСХ-ны ХАНСГ-ын гэрээт ажилтан

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Хаягт: Монгол Улс, Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44 Засгийн газрын III байр

Утас: (976-51)-265543, 1900-1212

Цахим хуудас: <http://nso.mn>, www.1212.mn И-мэйл: information@nso.mn

Зөвлөмж

Энэхүү танилцуулгад агуулагдсан гол мэдээллүүд Үндэсний статистикийн хорооны мэдээллийн санд байдаг бөгөөд хувь хүн, албан байгууллага ямар нэгэн түсгай зөвшөөрөлгүйгээр бүрэн ашиглаж болно.

Агуулга

Хүснэгтийн жагсаалт	5
Зургийн жагсаалт.....	6
Өмнөх үг.....	7
Ойлголт тодорхойлолт.....	8
1. ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	12
1.1. АРГАЧЛАЛЫН ШИНЭЧЛЭЛТ	13
1.2. ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ..	14
2. АЖИЛ ХАЙГЧ БОЛОН БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД	20
2.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ	21
2.2. АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	22
2.3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	24
3. ТӨРИЙН АЛБАН ХААГЧ	28
3.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ	29
3.2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	30
4. МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАЖ БУЙ АЖИЛЛАГЧ	36
4.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ	37
4.2. МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАЖ БАЙГАА ГАДААД ИРГЭДИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	38
5. ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААН.....	43
5.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, ДАВТАМЖ, УРСГАЛ.....	44
5.2. ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААНЫ СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	44
6. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО	47
6.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ	48
6.2. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ...	49

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд, мянган хүн	15
Хүснэгт 1.2. Боломжит ажиллах хүч, сүүлийн 30 хоногт цалинтай ажил олох болон бизнес	17
эрхлэх гэж оролдоогүй шалтгаан, дүнд эзлэх хувиар, 2019 он	17
Хүснэгт 2.1. Ажил хайж бүртгүүлсэн иргэд, насны бүлэг, хүйсээр, 2019 оны эцэст	23
Хүснэгт 2.2. Бүртгэлтэй ажилгүй иргэд, хөдөлгөөнөөр, мянган хүнээр	24
Хүснэгт 3.1. Төрийн улс төрийн албан хаагчдын хүйсийн харьцаа, албан тушаалаар	38
Хүснэгт 3.2. Төрийн захиргааны албан хаагчдийн хүйсийн харьцаа	39
Хүснэгт 4.1. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, оны эцэст, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар	38
Хүснэгт 4.2. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, оны эцэст, улс орноор	39
Хүснэгт 4.3. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, оны эцэст, аймаг нийслэлээр	41
Хүснэгт 5.1. Хөдөлмөрийн хамтын маргаан	44
Хүснэгт 5.2. Хөдөлмөрийн хамтын маргаанд хамрагдагчид, салбараар	45
Хүснэгт 5.3. Хөдөлмөрийн хамтын маргаанд хамрагдсан ажиллагчид, аймаг нийслэлээр	45
Хүснэгт 6.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, аймаг, нийслэл, бүсээр	49
Хүснэгт 6.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар	51
Хүснэгт 6.3. Үйлдвэрлэлийн осол орсон хүний тоо салбарын ангилаар, хөнгөн, хүнд зэргээр	53

Зургийн жагсаалт

Зураг 1.1. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны гол салбараар	15
Зураг 1.2. Хөдөлмөрийн дутуу ашиглалт, насны бүлгээр, хувиар, 2019 он	16
Зураг 1.3. Ажилгүй хүн, өмнөх ажлаасаа гарсан шалтгаанаар, дүнд эзлэх хувиар, 2019 он.....	17
Зураг 1.4. Албан бус хөдөлмөр эрхлэгч, салбараар, 2019 он	18
Зураг 1.5. Хөдөлмөрийн зарим суурь үзүүлэлт, аймгаар, 2019 он.....	19
Зураг 2.1. Ажил хайж бүртгүүлсэн иргэд, төрөл	22
Зураг 2.2. Ажил хайж бүртгүүлсэн иргэд, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар	24
Зураг 2.3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлэг, дүнд эзлэх хувиар.....	25
Зураг 2.4. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд, ажил хайж буй шалтгаанаар, дүнд эзлэх хувиар, 2019 оны эцэст.....	25
Зураг 2.5. Ажилд зүүчлагдан орсон хүн, насны бүлэг, боловсролын түвшнээр, дүнд эзлэх хувиар, 2019 оны эцэст.....	26
Зураг 2.6. Хөгжлийн бэрхшээлтэй бүртгэлтэй ажилгүй иргэд, хүйсээр.....	26
Зураг 2.7. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшин, хүйсээр, 2019 он	27
Зураг 3.1. Төрийн албан хаагчид ангилалаар	30
Зураг 3.2. Төрийн албан хаагчид боловсролын түвшинээр	30
Зураг 3.3. Төрийн нийт албан хаагчдын тоонд эмэгтэйчүүдийн эзлэх хувь	31
Зураг 3.4. Төрийн албан хаагчид, байршлаар.....	31
Зураг 3.5. Төрийн албан хаагчид, насны бүлгээр.....	31
Зураг 3.6. Төрийн албанд ажиллагчдын тоо, салбараар.....	32
Зураг 3.7. Төрийн улс төрийн албан хаагчид, насны бүлгээр	33
Зураг 3.8. Төрийн захиргааны албан хаагчид, албан тушаалын ангилалаар	34
Зураг 3.9. Төрийн үйлчилгээний албан хаагчид, албан тушаалын төрлөөр.....	35
Зураг 3.10. Төрийн үйлчилгээний албан хаагчид, салбараар	35
Зураг 4.1.Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, оны эцэст, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, хувиар	39
Зураг 4.2. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, оны эцэст, улс орноор, нийт дүнд эзлэх хувиар.....	40
Зураг 4.3. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, насны бүлгээр, эзлэх хувиар ..	40
Зураг 4.4. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, оны эцэст, бүс, хувиар	42
Зураг 5.1. Хөдөлмөрийн хамтын маргаан, шийдэгдсэн байдлаар.....	46
Зураг 6.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, хүйсээр	50
Зураг 6.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, насны бүлгээр, 2016-2019 он	50
Зураг 6.3. Осолдогчид, ажил мэргэжлээр, 2019	52
Зураг 6.4. Осолдогчид, осолд орсон шалтгаанаар, 2019.....	52
Зураг 6.5. Ажлын байр дахь хүнд болон хөнгөн осол гэмтлийн давтамжийн хувь (100.000 ажилтан бүрт).....	54

Өмнөх үг

Үндэсний статистикийн хороо нь Монгол Улсын статистикийн тухай хуульд заагдсан 4-н үндсэн үзүүлэлтийг болон хөдөлмөрийн статистикийн бүхий л мэдээллийг дараах эх үүсвэртэйгээр албан ёсны статистикийн мэдээлэл болгон тархааж байна. Үүнд:

1. Ажиллах хүчний судалгааг улирал, жилээр;
2. Ажил хайгч иргэд болон бүртгэлтэй ажилгүй иргэдийн сарын мэдээг Хөдөлмөрийн яамны захиргааны статистик мэдээллийн;
3. Хөдөлмөрийн хамтын маргааны жилийн мэдээг Хөдөлмөрийн яамны захиргааны статистик мэдээллийн;
4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улирлын мэдээг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын захиргааны мэдээллийн;
5. Төрийн албан хаагчдын жилийн мэдээг Төрийн албаны зөвлөлийн мэдээллийн эх үүсвэртэйгээр албан ёсны статистик болгон нийтэд тархааж байна.

Дэд салбар		Эх үүсвэр	Эхэлсэн хугацаа	Давтамж
1.	Ажиллах хүчний судалгаа	Үндэсний статистикийн хороо	2002-2003 2006 ~	Улирал, жил
2.	Ажил хайгч иргэн, бүртгэлтэй ажилгүй иргэд	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	БАИ-2008 АХИ-2014	Сар бүр
3.	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй гадаад ажиллагчид	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	2009-2019 2019 ~	Хагас жил Улирал
4.	Төрийн албан хаагчид	Төрийн албаны зөвлөл	2005 ~	Жил
5.	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	2016 ~	Улирал
6.	Хөдөлмөрийн хамтын маргаан	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	2017 ~	Жил

Хөдөлмөрийн зах зээлийн статистикийн үндсэн үзүүлэлтүүд нь Монгол Улсын хүн ам, нийгмийн статистикийн асуудлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийх, бодлого боловсруулах болон шийдвэр гаргах, дүгнэх түвшинд ашиглагдах мэдээллийн чухал эх үүсвэр юм. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн статистикийн тоон мэдээлэл яагаад чухал вэ? Үүнийг хамгийн энгийнээр тайлбарлавал, олон айл өрхийн амьжиргааны түвшин нь тухайн өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтээс шууд хамаарч байдаг. Иймээс энэхүү танилцуулгаар дээрх хүснэгтэд дурдсан хөдөлмөрийн 5 дэд салбарын статистикийн мэдээллийн өнөөгийн байдал, өөрчлөлтийг боломжит оноор нэгтгэн бэлтгэлээ.

Ойлоглт тодорхойлолт

Үзүүлэлт	Ойлоглт, тодорхойлолт
Хөдөлмөрийн зах зээл	Ажиллах хүчийг худалдах, худалдан авах субъектүүдийн хоорондын харилцаа
Хөдөлмөрийн насны хүн ам	15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.
Ажиллах хүч	тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	Сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас энэ боломжит ажиллах хүчийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ.
Ажиллагч	Зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ. Хөдөлмөр эрхлэгчдийг ажлын байрандаа байгаа болон түр эзгүй байгаа гэж хоёр бүлэгт хувааж авч үзнэ.
Хөдөлмөрийн дутуу ашиглалт	Хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно. Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг Ажилгүй хүн, Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч болон Боломжит ажиллах хүчээр хэмжинэ.
Ажилгүй хүн	Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм. Үүнд: а. хөдөлмөр эрхлээгүй гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн ажил хийгээгүй, ажиллагч гэдэг тодорхойлолтод хамаарахгүй байхыг; б. ажил хийхэд бэлэн гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт эсвэл тухайн хугацаанаас хойш ирэх хоёр долоо хоногт ажил хийж эхлэхэд бэлэн байхыг; в. ажил хайж байгаа гэж сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүн юм. Ажил хайх гэдгийг ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын


	<p>мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг ойлгоно. Харин ажлын байрны талаар мэдээлэл авсан ч ажил олгогчид хандаагүй бол идэвхтэй оролдлого хийсэн гэж үзэхгүй.</p>
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	<p>Тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 40 цагаар авч үзнэ.</p>
Боломжит ажиллах хүч	<p>Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм. Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд:</p> <p>а. Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн;</p> <p>б. Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.</p>
Албан бус салбар	<p>Хөдөө аж ахуйн бус салбарт орлого олох зорилготойгоор зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулдаг өрхийн хоршоологдоогүй аж ахуй нэгжийг ойлгоно. Тэд ямар нэгэн бүрэн хөтөлсөн данс тооцоогүй, албан ёсны бүртгэлийг дагаж мөрддөггүй буюу аж ахуйн зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, орлогын албан татварын талаарх мэдээлэлд бүрэн хамрагдаагүй байдаг.</p>
Албан салбар	<p>Төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн тогтолцоотой үйлдвэрийн газар буюу зах зээлийн бус хуулийн этгээдүүд болон зах зээлд борлуулах зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эрхэлж буй албан ёсны бүртгэлд бүрэн хамрагдсан хуулийн этгээд, хуулийн этгээдийн хяналт дор (орлогын албан татварын талаарх мэдээлэлд бүрэн хамрагдсан) үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, өрхийн аж ахуйн үйл ажиллагаа юм.</p>
Албан бус хөдөлмөр эрхлэгч	<p>Албан бус ажлын байранд хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Албан бус хөдөлмөр эрхлэгчид дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд:</p> <p>а. Тухайн хугацаанд хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй, орлогын албан татвар, өвчтэй байсны тэтгэмж, ээлжийн амралт олгодоггүй, нийгмийн хамгааллын бусад асуудал хангагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч;</p> <p>б. Албан бус салбарт ажиллаж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч болон цалин хөлстэй ажиллагчгүй бие даасан ажиллагч;</p> <p>г. Зөвхөн өөрийн эцсийн хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй өрхөд цалин хөлстэй ажиллагч;</p> <p>д. Хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүд орно.</p>

Албан бус салбарт ажиллагч	Хөдөлмөр эрхлэлтийн статусаас үл хамааран, тухайн хугацаанд наад зах нь нэг албан бус салбар дахь эдийн засгийн нэгжид ажиллаж байгаа ажиллагч юм.
Албан салбарт албан бус хөдөлмөр эрхлэгч	Албан салбар дахь албан бус ажлын байранд хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм.
Албан бус эдийн засагт ажиллагч	Албан бус салбарт болон албан салбар дахь албан бус ажлын байранд хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм.
Ажил хайгч иргэн	Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг хэлнэ.
Бүртгэлтэй ажилгүй иргэд	Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.
Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэн	Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид болон төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллага, шашны байгууллагад цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа хүмүүс юм.
Үйлдвэрлэлийн осол	Хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг хэлнэ.
Хурц хордлого	Цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг хэлнэ.
Осолдогч	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэнийг хэлнэ.
Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн нэг ажилтан	Иргэнийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нэг тохиолдол гэж үзнэ. Хэрвээ нэг осол, хордлогод нэгээс дээш тооны хүн өртсөн бол осолдогч тус бүрээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол гэж тооцно.
Бүлэг осол, хурц хордлого	Нэг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод 2, түүнээс дээш тооны ажилтан, иргэн өртөхийг хэлнэ.
Хөдөлмөрийн маргаан	Хөдөлмөрийн тодорхой нэг асуудал болон бүлэг асуудлын хүрээнд ажиллагч болон ажил олгогчийн хооронд үүссэн ашиг сонирхлын зөрүүг ойлгоно. Ашиг сонирхлын зөрүүгээ арилгах талаар ажилтан эсвэл ажил олгогчоос явуулж буй үйл ажиллагааг хамтын ажиллагаа (industrial action) гэж үзнэ.
Хөдөлмөрийн хамтын маргаан	Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, биелүүлэх, биелэлтэд нь хяналт тавих явцад гэрээ, хэлэлцээрт оролцогч талуудын хооронд үүссэн саналын зөрүүг хэлнэ.

Ажил хаялт (страйк)	Хөдөлмөрийн хамтын маргааныг шийдвэрлэх зорилгоор ажилтнаас үүрэгт ажлаа сайн дурын үндсэн дээр тодорхой хугацаагаар бүрэн буюу хэсэгчлэн түр зогсоохыг хэлнэ.
Ажлын байрыг түр хаах (локаут)	Ажил олгогч нь ажиллагчдын тавьсан шаардлагыг хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэх, эсэргүүцэх, эсхүл гомдлоо илэрхийлэх зорилгоор ажил олгогч нэг буюу хэд хэдэн ажлын байрыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр хаах, эсхүл ажиллагчдын ажлын хэвийн үйл ажиллагаа явуулахад нь саад учруулахыг хэлнэ.
Ажлын байрыг түр хаах (пикет)	Ажил хаялтад оролцогчдын ажлын байранд ажилтан түр ажиллуулахгүй байх зорилгоор ажилтны төлөөлөгчид нь аж ахуйн нэгж, байгууллагыг түр хаахыг хэлнэ.
Төрийн албан хаагч	Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг хэлнэ.



1. ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



1.1. АРГАЧЛАЛЫН ШИНЭЧЛЭЛТ

Хөдөлмөрийн зах зээл маш хурдацтай өөрчлөгдөж буй өнөөгийн цаг үетэй хөл нийлүүлэн, нөхцөл байдлыг бодитоор харахын тулд Олон улсын хөдөлмөрийн статистикчид (ОУХС)-ын 19-р бага хурлын тогтоолыг өөрийн орны онцлогт тусган, ойлголт, тодорхойлолт, аргачлалаа шинэчлэн боловсронгуй болгох шаардлагын дагуу 2019 оны 1 дүгээр сараас эхлэн Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг мөрдөж байна.

Гол шинэчлэлт:

- Хөдөлмөрийн насны дээд хязгаарыг тогтоож өгөхгүйгээр, 15 ба түүнээс дээш болгосон.
- Ажиллагч гэдэгт зөвхөн цалин, ашгийн төлөө ажиллаж байгаа хүнийг хамааруулсан. Өмнөх аргачлалын дутуу цалингүй дадлагажигч ажилтан, сайн дурын ажилтан нь ажиллагч болж байсан бол шинэ аргачлалаар ажиллагч болохгүй, ажилгүй хүн эсвэл ажиллах хүчнээс гадуурх хүн ам болж байгаа.
- Ажиллагчдын үндсэн ажлын шалгуур нь хуучнаар хамгийн их цалин хөлс, орлого олдог ажил нь байсан бол шинэ аргачлалын дагуу цалин, орлогоос үл хамааран хамгийн их цаг зарцуулдаг ажлыг үндсэн ажил гэж тодорхойлсон.
- Хуучин аргачлалаар Хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг зөвхөн ажилгүй хүний хүрээнд хэмждэг байсан бол шинэ аргачлалаар өргөн хүрээнд Хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтүүд болох ажилгүй хүн + боломжит ажиллах хүч + цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлтээр хэмжих болсон.

Гол ач холбогдол:

- Амьдрал дээр хөдөлмөрийн наснаас дээш насны хүн хөдөлмөр эрхэлж эсвэл хөдөлмөрлөх хүсэл зорилготой байна (жолооч, оёдолчин гэх мэт энгийн ажил мэргэжлээс эхлээд тодорхой үр чадвар шаардсан дотоодын зөвлөхөөр ч ажиллаж байна). Иймд хөдөлмөрийн насны хүн амын насны дээд хязгаарыг байхгүй болгосон. Ингэснээр хөдөлмөрийн статистикийн хамрах хүрээг нэмэгдүүлэн хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо, цаашлаад ДНБ-ний тооцоолол илүү нарийн илэрхийлэгдэх юм.
- Хөдөлмөрийн дутуу ашиглалтын шинэ үзүүлэлтийг бий болгосноор хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ нь хангагдахгүй байгаа хүн амыг бүрэн илэрхийлэх, цаашлаад хэнд ямар бодлого хөтөлбөрийг чиглүүлэх вэ гэдэг илүү дэлгэрэнгүй суурь тоон мэдээлэл бий болох юм. Өөрөөр хэлбэл, улс орнууд ажилгүйдлийг бууруулах бодлогын суурь тоог зөвхөн ажилгүй хүнээр авахад, хэрэгжүүлэх явцад ажилгүй хүн бус бага цагаар ажиллаж байгаа, нэмэлт ажил хайж, хийхэд бэлэн байгаа ажиллагчид ч хамрагдаж байна. Энэ нь хөтөлбөрийн зорилтын үр дүн хангалттай хэрэгжихгүйд хүргэж байна гэж үзэн ОУХБ-аас хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтийг шинээр бий болгосон. Манай улсын хувьд ч хуучин аргачлалаар ажилгүй хүнийг суурь болгож тэдгээрт чиглэсэн шинэ ажлыг бий болгох, ажлын байраар хангах чиглэлийн хөтөлбөр зонхилж байсан бол шинэ аргачлалын дагуу:

- Долоо хоногт 40 цагаас бага, нэмэлт ажил хайж, хийхэд бэлэн байгаа Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийг бий болгосноор нэмэлт ажлын байраар хангах болон цалин, хөлсний бодлого чиглэлээр;
- Ажилгүй ч ажил хайх, ажил хийхэд бэлэн гэсэн 2 шалгуурын аль нэгийг нь хангаж байгаа (2-ланг нь зэрэг хангасан бол ажилгүй хүн) Боломжит ажиллах хүчнийг шинээр бий болгосноор ажлын байраар хангах болон тэдгээрт чиглэсэн мэргэжил, үр чадвар олгох сургалт явуулах чиглэлийн бодлого хэрэгжүүлэхэд суурь тоон мэдээлэл бий болох юм.

Хөдөлмөрийн зах зээлийн ашиглагдахгүй байгаа нөөцийг зөвхөн бүртгэлтэй ажилгүй эсвэл нийт ажилгүй иргэдийн хүрээнд хэмжих нь өрөөсгөл асуудал юм. Цаашлаад бүртгэлийн систем хөгжсөн, хөгжингүй улс орнуудад нийт ажилгүй хүний ихэнх нь Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагадаа бүртгүүлсэн байдаг.

1.2. ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хөдөлмөрийн зах зээлийн гол мэдээллийн эх үүсвэр нь “Ажиллах хүчний судалгаа(АХС)” бөгөөд, 2002-2003 онд Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын санхүүжилтээр анх удаа олон улсын нийтлэг жишиг аргачлалын дагуу улирлаар явуулсан. 2004 онд Монгол Улсын “Статистикийн тухай” хуулинд нэмэлт заалт оруулсны дагуу 2006 оноос эхлэн АХС-г улирлаар явуулж, үр дүнг нэгтгэн тархааж байна.

Ажиллах хүчний судалгааг 2019 оноос эхлэн Хөдөлмөрийн статистикийн шинэ ойлголт, аргачлалын дагуу явуулж байгаа нь бодлого, төлөвлөлтөд ашиглах, бодлогын шинжилгээ хийхэд хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтүүд, тэдгээрийн түвшин гэх мэт илүү дэлгэрэнгүй мэдээллээр хангах ач холбогдолтой болсон. Мөн албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ямар секторт (албан болон албан бус) ажиллаж байгааг тодорхойлох мэдээллийг бий болгож, ангилан харуулсан.

Энэ бүлэгт уг судалгааны 2019 оны жилийн үр дүнг товч танилцуулах бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг Ажиллах хүчний судалгааны 2019 оны тусгайлсан тайлангаас авах боломжтой.

Ажиллах хүчний судалгааны 2019 оны байдлаар ажиллах хүчний 1146.2 (90.0%) мянга нь ажиллагчид, 127.7 (10.0%) мянга нь ажилгүй хүн байна. Харин улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны ажиллах хүчнээс гадуурх хүн ам 832.2 мянга байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ) улсын хэмжээнд 60.5 хувь, хүйсийн хувьд эрэгтэйчүүдийнх 68.3 хувь, эмэгтэйчүүдийнх 53.4 хувьтай байна.

Хөдөлмөрийн нөөцөд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 54.4 хувь байна. Хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүд 60.8 хувь, эмэгтэйчүүд 48.7 хувь байна.

Хүснэгт 1.1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд, мянган хүн


Үзүүлэлт	2016	2017	2018	2019
Бүгд				
Ажиллах хүч	1 275.6	1 357.4	1 358.6	1 273.9
Ажиллагчид	1 147.8	1 238.3	1 253.0	1 146.2
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	3.6	9.9	8.0	15.1
Ажилгүй хүн	127.8	119.1	105.6	127.7
Бүртгэлтэй ажилгүй иргэд ¹	34.4	25.5	25.0	20.8
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	831.4	863.0	868.0	832.2
Боломжит ажиллах хүч	-	-	-	58.8
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	-	-	-	773.4
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	60.5	61.1	61.0	60.5
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	54.5	55.8	56.3	54.4
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, %	-	-	-	15.1
Ажилгүйдлийн түвшин, %	10.0	8.8	7.8	10.0
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %	-	-	-	11.2
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, %	-	-	-	14.0

¹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа

Ажиллагчдын 88.3 мянга (7.7%) нь 15-24 насныхан (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд), 941.4 мянга (82.1%) нь 25-аас 54 насныхан (ерөнхий ажиллах хүчний насныхан), 96.8 мянга (8.4%) нь 55-64 насныхан (тэтгэвэрт гарахад ойрхон байгаа) болон 19.6 мянга (1.7%) нь 65 ба түүнээс дээш насныхан байна.

Зураг 1.1. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны гол салбараар




Нийт ажиллагчдын 608.7 мянга (53.1%) нь үйлчилгээний, 290.2 мянга (25.3%) нь хөдөө аж ахуйн, 247.3 мянга (21.6%) нь үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна.

Эх үүсвэр: ҮСХ, Ажиллах хүчний судалгаа

Хөдөлмөрийн дутуу ашиглалт 2019 онд улсын хэмжээнд 201.6 мянга байгаагийн 127.7(63.3%) мянга нь ажилгүй хүн, 58.8 (29.2%) мянган нь боломжит ажиллах хүч, 15.1(7.5%) мянга нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид байна.

Зураг 1.2. Хөдөлмөрийн дутуу ашиглалт, насны бүлгээр, хувиар, 2019 он



Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг үнэлэх дөрвөн үзүүлэлтийг 2019 оны байдлаар авч үзэхэд хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 15.1 хувь, ажилгүйдлийн түвшин 10.0 хувь байна. Харин ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 14.0 хувь, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин 11.2 хувь байна. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтүүдийг 15-24 насныхан (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд), 25-аас 54 насныхан (ерөнхий ажиллах хүчний насныхан) болон 55-64 насныхан (тэтгэвэрт гарахад ойрхон байгаа), 65 ба түүнээс дээш насны

гэсэн насны 4 бүлгээр харуулав.

Эх үүсвэр: ҮСХ, Ажиллах хүчний судалгаа

Ажилгүй хүмүүсийн 86.6 (67.8%) мянга нь өмнө нь хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд өмнөх ажлаасаа гарсан шалтгаанаар нь авч үзвэл, 17.5 (20.1%) мянга нь өөрийн хүсэлтээр, 16.8 (19.4%) мянга нь түр ажлын байр байсан, 14.1 (16.2%) мянга нь хувийн, гэр бүлийн шалтгаанаар, 8.1 (9.4%) мянган нь цалин хөлс тохирохгүй байсан учраас гэсэн шалтгаантай хүмүүс хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Нийт ажилгүй хүний 66.3 (51.9%) 15-34 насныхан байна. Харин 29.9 (23.4%) 15-24 насныхан байна. 15-34 насны ажилгүйчүүдийн хувьд 45.8 (69.1%) мянга нь өмнө нь хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд өмнөх ажлаасаа гарсан шалтгаанаар нь авч үзвэл, 9.0 (26.3%) мянга нь түр ажлын байр байсан, 7.1 (20.6%) мянга нь өөрийн хүсэлтээр, 6.1 (18.0%) мянга нь хувийн/гэр бүлийн шалтгаан, 3.1 (9.0%) мянган нь цалин хөлс тохирохгүй байсан учраас гэсэн шалтгаантай хүмүүс хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Зураг 1.3. Ажилгүй хүн, өмнөх ажлаасаа гарсан шалтгаанаар, дүнд эзлэх хувиар, 2019 он



Хүснэгт 1.2. Боломжит ажиллах хүч, сүүлийн 30 хоногт цалинтай ажил олох болон бизнес эрхлэх гэж оролдоогүй шалтгаан, дүнд эзлэх хувиар, 2019 он

Шалтгаан	Бүгд		15-24 насныхан		15-34 насныхан	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Өмнөх ажил хайлтын үр дүнг хүлээж байна	1 041	1.8	136	1.7	857	3.7
Өмнөх ажлаас утасдахыг хүлээж байгаа	620	1.1	-	-	27	0.1
Улирлаас шалтгаалаад эхлэхийг нь хүлээж байгаа	3 429	5.8	268	3.3	1 170	5.2
Ажил хайгаад залхсан, ажлын байр байхгүй гэж бодож байна	8 783	14.9	1 322	16.5	3 589	15.8
Ур чадварт тохирох ажил байхгүй түршлага байхгүй	4 801	8.2	261	3.3	1 435	6.3
Ажил олгогчдын зүгээс хэтэрхий залуу/хөгшин байна гэж үздэг	7 884	13.4	-	-	124	0.5
Суралцаж байсан сургалтад хамрагдаж байгаа	3 830	6.5	3 183	39.7	3 830	16.9
Гэр бүлийн шалтгаанаар	12 352	21.0	1 265	15.8	5 305	23.4
Өрхийн хэрэгцээний ХАА-н болон загас үржүүлгийн ажилд туслахаар	2 427	4.1	485	6.0	1 034	4.6
Өвчтөн хөгжлийн бэрхшээлтэй	3 510	6.0	66	0.8	727	3.2
Бусад орлогын эх үүсвэртэй	1 526	2.6	-	-	-	-
Ажлаа эхлүүлэхээр хүлээж байгаа	1 428	2.4	46	0.6	406	1.8
Ажил хайсан/бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэхийг оролдсон	3 312	5.6	314	3.9	2 111	9.3
Бусад	3 854	6.6	677	8.4	2 084	9.2
Бүгд	58 797	100.0	8 023	100.0	22 699	100.0


Эх үүсвэр: УСХ, Ажиллах хүчний судалгаа

Боломжит ажиллах хүч 58.8 мянга байгаа бөгөөд ажил хайгаагүй шалтгаанаар нь авч үзвэл, 12.3 (21.0%) мянга нь гэр бүлийн, 8.8 (14.9%) мянга нь ажил хайгаад залхсан, ажлын байр байхгүй гэж бодож байна, 7.9 (13.4%) мянга нь ажил олгогчдын зүгээс хэтэрхий залуу, хөгшин байна гэж үздэг гэсэн шалтгаантай хүмүүс хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Боломжит ажиллах хүчний 22.7 (38.6%) мянга нь 15-34 насны залуучууд байгаагаас ажил хайгаагүй шалтгаанаар нь авч үзэхэд, 5.3 (23.4%) мянга нь гэр бүлийн, 3.8 (16.9%) мянга нь суралцаж байсан, сургалтад хамрагдаж байгаа, 3.6 (15.8%) мянга нь ажил хайгаад залхсан, ажлын байр байхгүй гэж бодож байна гэсэн шалтгаантай хүмүүс хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Нийт ажиллагчдын 290.2 (25.3%) мянга нь хөдөө аж ахуйн салбарт, 856.0 (74.7%) мянга нь хөдөө аж ахуйн бус салбарт ажиллагчид эзлэж байна. Хөдөө аж ахуйн бус салбарт ажиллаж буй ажиллагчдын 270.3 (31.6%) мянга нь албан бус ажлын байранд хөдөлмөр эрхэлж буй албан бус хөдөлмөр эрхлэгч байна. Тэдгээрийн 157.6 (58.3%) мянга нь албан салбарт, 112.7 (41.7%) мянга нь албан бус салбарт ажиллаж байна.


Зураг 1.4. Албан бус хөдөлмөр эрхлэгч, салбараар, 2019 он



Албан бус хөдөлмөр эрхлэгч 270 328

Эх үүсвэр: ҮСХ, Ажиллах хүчний судалгаа


Зураг 1.5. Хөдөлмөрийн зарим суурь үзүүлэлт, аймгаар, 2019 он





2. АЖИЛ ХАЙГЧ БОЛОН БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, мянган хүн



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛ 2019 ОНД



2.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ

Манай улсын хувьд ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэдийн статистикийн мэдээллийг цуглуулах ажлыг тодорхой үе шаттайгаар шинэчлэн боловсруулж ирснийг дор харууллаа.

1997

1997 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 71 тоот тушаалаар батлагдсан Ажилгүйчүүдийн сарын мэдээний /Маягт АХ-3/

2011

2011 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А/67 тоот тушаалаар батлагдсан анхан шатны бүртгэлийн /ХЗЗ-1, ХЗЗ-2, ХЗЗ-3 маягт/

2011


2011 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн Үндэсний Статистикийн хороо, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан /Маягт ХЗЗ-4а, ХЗЗ-4б, ХЗЗ-5, ХЗЗ-6а, ХЗЗ-6б, ХЗЗ-7а, ХЗЗ-7б, ХЗЗ-7в/

2014

2014 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс Ажил хайгч иргэний хөдөлгөөний /Маягт ХЗЗ-6/, Ажил хайгч иргэний/Маягт ХЗЗ-7а,7б/, Бүртгэлтэй ажилгүй иргэний хөдөлгөөний/Маягт ХЗЗ-6/, Бүртгэлтэй ажилгүй иргэний /Маягт ХЗЗ-7а, 7б/, Ажлын шинэ байранд орсон иргэний сарын мэдээ /Маягт ХЗЗ-5а,5б,5в/

Энэхүү мэдээллийг батлагдсан маягт, зааврын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас сар бүр хүлээн авч, нягтлан шалгаж, бүртгэлтэй ажилгүй иргэд, шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд, бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажилд орсон хүн зэрэг үзүүлэлтүүдийг сар, жилийн бюллетень, танилцуулга болон статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn сайтад байршуулан нийтэд тархааж байна.

Мэдээллийн урсгалын схем



2.2. АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2019 оны эцэст 37.0 мянга, үүнээс 20.8 (56.0%) мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 16.2 (44.0%) мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Зураг 2.1. Ажил хайж бүртгүүлсэн иргэд, төрөл



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажил хайж бүртгүүлсэн иргэдийн 60.5 хувь нь 15-34 насны залуучууд эзэлж байгаа ба энэ үзүүлэлт Дорнод, Өмнөговь, Баянхонгор аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас 1.2-6.5 пунктээр илүү байна. Ажил хайж бүртгүүлсэн иргэд 2014-2019 оны дунджаар 42.8 мянга байгаагийн 22.6 (52.8%) мянга нь эмэгтэй байна.

Хүснэгт 2.1. Ажил хайж бүртгүүлсэн иргэд, насны бүлэг, хүйсээр, 2019 оны эцэст


Аймаг, нийслэл	Бүгд		15-24		25-34		35-44		45-54		55-59		60+	
	Эмэгтэй	Эмэгтэй	Эмэгтэй	Эмэгтэй	Эмэгтэй	Эмэгтэй	Эмэгтэй	Эмэгтэй	Эмэгтэй	Эмэгтэй	Эмэгтэй	Эмэгтэй	Эмэгтэй	
Бүгд	37044	19016	11144	5729	11282	5901	8194	4295	5020	2549	1022	378	382	164
Баруун бүс	5953	3006	1167	633	2027	1113	1415	675	1016	454	236	82	92	49
Баян-Өлгий	1325	617	172	83	491	257	342	143	229	100	60	19	31	15
Говь-Алтай	965	516	212	118	335	195	218	114	135	64	49	16	16	9
Завхан	711	387	194	112	196	114	144	80	143	65	19	5	15	11
Увс	1121	575	240	132	365	201	274	140	201	92	34	8	7	2
Ховд	1831	911	349	188	640	346	437	198	308	133	74	34	23	12
Хангайн бүс	7276	3862	1701	954	2352	1247	1822	985	1124	565	186	68	91	43
Архангай	1348	732	280	176	452	239	367	194	197	93	25	13	27	17
Баянхонгор	561	276	197	99	168	81	97	50	80	38	9	4	10	4
Булган	1450	709	244	134	436	218	410	202	298	137	46	10	16	8
Орхон	1384	780	292	177	473	264	364	208	209	117	40	14	6	-
Өвөрхангай	1167	662	332	186	363	214	305	175	154	84	11	3	2	-
Хөвсгөл	1366	703	356	182	460	231	279	156	186	96	55	24	30	14
Төвийн бүс	5202	2597	1162	580	1765	884	1316	678	781	408	151	40	27	7
Говьсүмбэр	386	216	101	61	129	72	99	52	51	29	4	1	2	1
Дархан-Уул	1656	912	244	133	586	317	490	280	285	170	42	11	9	1
Дорноговь	352	172	107	53	96	49	92	45	44	20	8	2	5	3
Дундговь	545	280	130	75	174	90	119	62	93	45	27	7	2	1
Өмнөговь	724	289	158	73	305	118	155	64	81	28	21	5	4	1
Сэлэнгэ	816	382	228	103	253	127	197	98	113	46	23	8	2	-
Төв	723	346	194	82	222	111	164	77	114	70	26	6	3	-
Зүүн бүс	3005	1410	739	333	1051	515	709	330	410	197	71	25	25	10
Дорнод	1612	713	391	168	605	271	365	158	198	94	34	14	19	8
Сүхбаатар	867	409	207	94	273	136	217	104	138	63	26	10	6	2
Хэнтий	526	288	141	71	173	108	127	68	74	40	11	1	-	-
Улаанбаатар	15608	8141	6375	3229	4087	2142	2932	1627	1689	925	378	163	147	55

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажил хайгч иргэдийн 0.8 хувийг магистр, доктор, 20.2 хувийг дипломын болон бакалаврын, 4.0 хувийг тусгай мэргэжлийн дунд, 5.2 хувийг техникийн болон мэргэжлийн, 59.6 хувийг бүрэн дунд, 10.2 хувийг суурь, бага боловсролтой болон боловсролгүй иргэд эзэлж байна.

Бүрэн дунд боловсролтой ажил хайгч иргэд 2014 онд 45.6 хувийг эзэлж байсан бол энэ үзүүлэлт нэмэгдсээр 2019 онд 59.6 хувь болж нийт ажил хайж бүртгүүлсэн иргэдийн талаас илүү хувийг эзэлж байна.

Зураг 2.2. Ажил хайж бүртгүүлсэн иргэд, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

2.3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Ажиллах хүчний судалгааны 2019 оны дүнгээр улсын хэмжээнд 127.7 мянган ажилгүй иргэд байна. Эдгээрээс хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн бүртгэлтэй ажилгүй иргэд 2019 оны эцэст 20.8 мянга болсны 10.9 мянга нь эмэгтэйчүүд байна.


Хүснэгт 2.2. Бүртгэлтэй ажилгүй иргэд, хөдөлгөөнөөр, мянган хүнээр

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Бүртгэлтэй ажилгүй иргэд	38.3	57.2	35.8	42.8	37	32.8	34.4	25.5	25.0	20.8
Шинээр бүртгүүлсэн иргэд	64.3	77.7	61.5	110.1	109.7	122.8	117.1	93.3	93.5	87.0
Ажилд зуучлагдан орсон иргэд	46.3	97.4	32.3	65.9	27.4	27.7	21.0	28.6	25.6	27.2
Ажил хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд	17.8	15	47.6	37.2	89.8	99.3	94.4	73.7	68.4	64.0

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2019 онд жилд давхардсан тоогоор ажилгүй 87.0 мянган иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 27.2 мянган иргэн ажилд зуучлагдан орж, 64.0 мянган иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан нь 2010 оныхтой харьцуулахад шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд 35.3 хувиар өссөн бол ажилд зуучлагдан орсон иргэд 41.3 хувиар буурсан байна. Харин ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 3.6 дахин нэмэгджээ.

Зураг 2.3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлэг, дүнд эзлэх хувиар




Тайлбар *- Насны ангилал өөрчлөгдсөн
Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

2019 оны байдлаар нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 57.4 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байгаа бол энэ нь 2010 оныхоос 0.6 пункт, 2015 оныхоос 3.9 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр авч үзвэл хоёр хүн тутмын нэг нь бүрэн дунд боловсролтой байна.

Зураг 2.4. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд, ажил хайж буй шалтгаанаар, дүнд эзлэх хувиар, 2019 оны эцэст




Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2015 оны эцэст 13.0 мянган хүн шинээр бүртгүүлсний 41.4 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байсан бол 2019 оны эцэст 10.1 мянган хүн шинээр бүртгүүлсний 53.6 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдээс 2019 оны эцэст 4.7 мянган хүн ажилд зуучлагдан орсны 2.7(57.9%) мянга нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид, 1.5 (32.3%) мянга нь төсөвт байгууллагад орсон байна.

Ажилд зуучлагдан орсон иргэдийн 63.8 хувийг 15-34 насны иргэд эзэлж байгаа бол 60.3 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд байна.


Зураг 2.5. Ажилд зуучлагдан орсон хүн, насны бүлэг, боловсролын түвшнээр, дүнд эзлэх хувиар, 2019 оны эцэст



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 345 (1.7%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа бөгөөд 168 (48.7%) нь эмэгтэйчүүд байна.


Зураг 2.6. Хөгжлийн бэрхшээлтэй бүртгэлтэй ажилгүй иргэд, хүйсээр



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 78.6 хувийг бүрэн дунд, дипломын болон бакалаврын дээд боловсролтой иргэд эзэлж байгаа нь энэ хэсэгт нийгмийн бодлого, шийдвэрээ түлхүү хандуулах шаардлагатай байгааг илтгэж байна.

Зураг 2.7. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшин, хүйсээр, 2019 он



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Бүрэн дунд боловсролтой бүртгэлтэй ажилгүй иргэд 2010 онд 45.2 хувь, 2015 онд 47.3 хувийг эзэлж байсан бол энэ үзүүлэлт нэмэгдсээр 2019 онд 52.9 хувь болж нийт бүртгүүлтэй ажилгүй иргэдийн талаас илүү хувийг эзэлж байна.



3. ТӨРИЙН АЛБАН ХААГЧ



3.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ

Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн системийн мэдээлэлийг Үндэсний статистикийн хороонд ирүүлж ҮСХороо нь албан ёсны статистик болгон тархааж байна.

Мэдээллийн урсгалын схем




Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн системийн мэдээлэлийг Үндэсний статистикийн хороонд ирүүлж ҮСХороо нь албан ёсны статистик болгон тархааж байна.

3.2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Төрийн албан хаагчид 2019 оны эцэст 198.5 мянга болж, өмнөх оны мөн үеэс 4.9 (2.5%) мянгаар өссөн байна. Төрийн албанд 2019 онд 4906 албан хаагч нэмэгдсэний 4194 (85.5%) нь төрийн үйлчилгээний, 484 (9.9%) нь төрийн тусгай, 182 (3.7%) нь төрийн улс төрийн, 46 (0.9%) нь төрийн захиргааны албан хаагчид байна.


Зураг 3.1. Төрийн албан хаагчид, ангилалаар



Төрийн нийт албан хаагчийн 39.1% нь эрэгтэй, 60.9% нь эмэгтэй албан хаагч байна. Тухайлбал, төрийн үйлчилгээний албан хаагчдын 71.6%, төрийн захиргааны албан хаагчдын 59.9%, төрийн тусгай албан хаагчдын 26.3%, төрийн улс төрийн албан хаагчдын 23.5% нь эмэгтэйчүүд байна.


Нийт төрийн албан хаагчдыг боловсролын түвшнээр авч үзэхэд, 61.1 хувь нь дээд, 33.5 хувь нь дунд, 5.4 хувь нь суурь болон түүнээс доош боловсролтой байна.

Зураг 3.2. Төрийн албан хаагчид, боловсролын түвшинээр



Албан тушаалын төрлийн хувьд авч үзэхэд, удирдах албан тушаалтан 7.6%, гүйцэтгэх албан тушаалтан 23.3%, туслах албан тушаалтан 69.1%-ийг тус тус эзэлж байна.

Зураг 3.3. Төрийн нийт албан хаагчдын тоонд эмэгтэйчүүдийн эзлэх хувь




Зураг 3.4. Төрийн албан хаагчид, байршлаар




Төрийн албан хаагчдын 33.3% нь төрийн төв байгууллага, түүний харьяа байгууллагуудад, 17.6% нийслэлийн захиргааны байгууллага, түүний харьяа байгууллагуудад, 49.1% нь нутгийн захиргааны байгууллага, түүний харьяа байгууллагуудад ажиллаж байна.

Зураг 3.5. Төрийн албан хаагчид, насны бүлгээр



Төрийн албан хаагчдыг насны ангиллаар авч үзэхэд, 25 хүртлэх насныхан (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд) 9.5 хувь, 26-аас 55 насныхан (ерөнхий ажиллах хүчний насныхан) 85.4 хувь, 56-аас дээш насныхан 5.1 хувийг эзэлж байна.

Зураг 3.6. Төрийн албанд ажиллагчдын тоо, салбараар




байгууллагын дийлэнх буюу 60 байгууллага нь төрийн суурь үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх бодлогын хүрээнд шинээр байгуулагдсан улсын төсвийн сургууль, цэцэрлэг, насан туршийн боловсролын төв, эмнэлэг, хүүхдийн сувилал байна. Бусад 21 байгууллагын хувьд, хүний нөөцийн мэдээллийг нь Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системд шинээр нэмж бүртгэсэн.

Хүснэгт 3.1. Төрийн улс төрийн албан хаагчдын хүйсийн харьцаа, албан тушаалаар

Албан тушаал	Бүгд	Хүйс			
		Эрэгтэй		Эмэгтэй	
		тоо	%	тоо	%
Сайд	16	15	93.7	1	6.3
Дэд сайд	13	8	61.5	5	38.5
Засаг дарга /аймаг, нийслэл/	22	22	100	-	-
Засаг даргын орлогч /аймаг, нийслэл/	39	32	82.1	7	17.9
Аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга	22	22	100	-	-
Дүүргийн ИТХ-ын дарга	9	5	55.6	4	44.4
Дүүргийн Засаг дарга	9	7	77.8	2	22.2
Дүүргийн Засаг даргын орлогч	20	15	75	5	25
Сумын ИТХ-ын дарга	330	271	82.2	59	17.8
Сумын Засаг дарга	330	286	86.7	44	13.3
Сумын Засаг даргын орлогч	330	269	81.5	61	18.5

Төрийн улс төрийн албан тушаалд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн 4 (44.4%) нь дүүргийн ИТХ-ын дарга, 5(38.5%) нь дэд сайдын алба хашиж байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн хувьд эрхэлж буй бусад албан тушаалаас өндөр байна.

Зураг 3.7. Төрийн улс төрийн албан хаагчид, насны бүлгээр




Төрийн улс төрийн албан хаагчдыг насны бүлгээр харвал 713 (19.9%) нь 46-50 насныхан байгаа бол хамгийн бага буюу 13 (0.4%) хувийг 21-25 насныхан эзэлж байна.

Хүснэгт 3.2. Төрийн захиргааны албан хаагчдийн хүйсийн харьцаа

Албан тушаал	Бүгд	Хүйс			
		Эрэгтэй		Эмэгтэй	
		тоо	%	тоо	%
Яамдын ТНБД	13	12	92.3	1	7.7
Агентлагийн дарга	30	29	96.7	1	3.3
Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дарга	22	18	81.8	4	18.2
Аймаг, нийслэлийн ИТХ-ын нарийн бичгийн дарга	22	17	77.3	5	22.7
Дүүргийн ИТХ-ын нарийн бичгийн дарга	9	5	55.6	4	44.4
Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга	330	136	41.2	194	58.8
Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга	9	8	88.9	1	11.1
Сумын Засаг даргын Тамгын газрын дарга	330	141	42.7	189	57.3
Нийт	765	366	47.8	399	52.2

Төрийн захиргааны албан хаагчдыг 29 (96.7%) нь агентлагын дарга, 12 (92.3%) нь яамны төрийн нарийн бичгийн дарга эрэгтэйчүүд байна. Харин 194 (58.8%) нь сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, 189 (57.3%) нь сумын засаг даргын тамгын газрын дарга албан тушаалтай эмэгтэйчүүд байна.

Зураг 3.8. Төрийн захиргааны албан хаагчид, албан тушаалын ангилалаар




Төрийн захиргааны албан хаагчидыг албан тушаалын ангилал, хүйсээр харьцуулахад албан тушаалын ангилал ахихад эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна.

Зураг 3.9. Төрийн үйлчилгээний албан хаагчид, албан тушаалын төрлөөр




Төрийн үйлчилгээний албан хаагчдын 59.5 (43.4%) мянга нь ерөнхий үйлчилгээ, 46.4 (33.8%) мянга нь бага, дунд боловсрол, 20.6 (15.1%) мянга нь эрүүл мэнд, 4.5 (3.3%) мянга нь мэргэжлийн боловсрол, 4.4 (3.2%) мянга нь соёл, урлагын салбарт ажиллаж байна.

Зураг 3.10. Төрийн үйлчилгээний албан хаагчид, салбараар





4. МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАЖ БУЙ АЖИЛЛАГЧ



4.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ

Монгол улсад хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаад иргэдийн статистикийн улирал тутам Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэдээллийн эх үүсвэртэйгээр тархааж байна.

Мэдээллийн урсгалын схем




Уг мэдээний анхан шатны бүртгэл нь ажил олгогч, аж ахуй нэгж, байгууллагууд 11 төрлийн бүрдүүлэх материалыг гадаадаас хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар уригдсан ажиллагч, мэргэжилтэн тус бүрээр болон ААНБ-ын хувьд бүрдүүлж ХХҮЕГ-т ирүүлдэг. Нэгдсэн мэдээллийн санг тэдгээр материалууд дээр үндэслэн баяжуулж, бүртгэл хөтөлдөг.

Хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийн тоо /Өссөн дүнгээр/ : Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаадын иргэнд

- (1) урьдчилсан зөвшөөрөл /урилга/ олгох
- (2) хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох
- (3) зөвшөөрлийн хугацааг сунгах
- (4) цуцлах

Тухайн тайлант хугацааны эцэст
Хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийн тоо /Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн дагуу идэвхтэй/



ХХҮЕГ



ГИХГ



ХХҮЕГ



ХХҮЕГ



ХХҮЕГ

Тодруулбал, гадаадаас хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллахаар уригдсан иргэн тус бүр болон тухайн ажиллах хүч авагч байгууллагын хувьд эдгээр бүрдүүлэх материалуудыг нэг

бүрчлэн бүрдүүлэн авчирч танилцуулахыг шаарддаг юм. Эдгээр 11 төрлийн бүрдүүлэх материалуудад 4 төрлийн анхан шатны маягт байдаг ба түүнийг хүн тус бүрээр бөглөн бүртгүүлдэг.

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаад ажиллагчдад цалин, орлого олох зорилготой ажиллагчдаас гадна цалин, орлого олох зорилгогүй сайн дурын үйл ажиллагаа эрхэлж буй иргэд багтсан байдаг.

4.2. МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАЖ БАЙГАА ГАДААД ИРГЭДИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Манай улсад 2019 оны байдлаар гадаадын 4.6 мянган иргэн хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлс, орлого олох зорилготойгоор хөдөлмөр эрхэлж, мөн цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байна. Ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 1.8 (38.3%) мянга нь уул уурхай, олборлолтын, 990 (21.5%) нь боловсролын, 759 (16.5%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 267 (5.8%) нь боловсруулах үйлдвэрлэлийн, 197 (4.3%) нь барилгын, 156 (3.4%) нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 151 (3.3%) нь тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, 58 (1.3%) нь олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа, 56 (1.2%) нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 2.0 (4.4%) мянга нь бусад салбарт ажиллаж байна.

Хүснэгт 4.1. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, оны эцэст, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Салбар	2016	2017	2018	2019
Бүгд	5 938	4 703	4 502	4 601
Уул уурхай, олборлолт	1 968	1 753	1 654	1 762
Боловсруулах үйлдвэрлэл	768	339	295	267
Барилга	963	363	121	197
Бөөний болон жижиглэн худалдаа,	612	649	782	759
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	94	100	121	151
Боловсрол	924	882	918	990
Бусад	609	617	611	475

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Зураг 4.1. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, оны эцэст, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, хувиар



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам


Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй нийт гадаадын иргэдийн 36.2 хувь нь БНХАУ-ын, 8.8 хувь нь Австрали Улсын, 7.1 хувь нь ОХУ-ын, 6.1 хувь нь БНСУ-ын, 5.3 хувь нь АНУ-ын, 4.3 хувь нь БНСВУ-ын, 3.7 хувь нь Филиппин Улсын, 3.5 хувь нь Өмнөд Африк Улсын, 2.8 хувь нь Их британи Улсын, 2.6 хувь нь Канад Улсын, 2.0 хувь нь Япон Улсын, 1.9 хувь нь Энэтхэг, 1.5 хувь нь Индонез Улсын, 14.2 хувь нь бусад улсын харьяат байна. Ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 3.8 (82.5%) мянга нь эрэгтэй, 0.8 (17.5%) мянга нь эмэгтэй байна.

Хүснэгт 4.2. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, оны эцэст, улс орноор

Улс орон	2016		2017		2018		2019	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Дүн	942	894	4 703	782	4 502	754	4 601	805
Австрали	23	37	334	30	472	39	407	31
Англи	11	14	115	19	148	24	128	18
АНУ	81	76	254	74	265	73	246	68
Вьетнам	-	-	198	1	243	2	199	2
Казахстан	24	20	47	18	42	16	44	17
Канад	16	17	170	17	149	14	120	13
ОХУ	205	176	343	167	300	143	325	175
Өмнөд Африк	3	7	117	6	144	3	162	1
БНСУ	86	87	305	88	273	77	280	80
БНАСАУ	137	116	340	19	-	-	-	-
Турк	10	12	59	9	28	5	48	1
Филиппин	29	28	93	36	150	62	168	88
БНХАУ	196	187	1 762	185	1 648	178	1 665	185
Энэтхэг	8	9	78	7	88	6	87	11
Япон	27	27	111	30	109	26	94	23
Бусад	86	81	377	76	443	86	628	92

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам


Зураг 4.2. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, оны эцэст, улс орноор, нийт дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажил эрхэлж буй гадаадын иргэдийг насны бүлгээр авч үзэхэд 5.3 хувь нь 20-24 насных, 9.6 хувь нь 25-29 насных, 12.2 хувь нь 30-34 насных, 14.6 хувь нь 35-39 насных, 13.9 хувь нь 40-44 насных, хамгийн их буюу 16.5 хувь нь 45-49 насны иргэд, хамгийн бага буюу 0.4 хувь нь 20 хүртэлх насных байна.

Зураг 4.3. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, насны бүлгээр, эзлэх хувар




Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 2.1 (45.8%) мянга нь Улаанбаатарт, 1.3 (28.4%) мянга нь Төвийн бүсэд, 0.8 (17.2%) мянга нь Зүүн бүсэд, 0.3 (6.6%) мянга нь Хангайн бүсэд, 0.1 (2.0%) мянга нь Баруун бүсэд ажиллаж байна.

Хүснэгт 4.3. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, оны эцэст, аймаг нийслэлээр

Аймаг, нийслэл	2016	2017	2018	2019
Баруун бүс	120	66	68	90
Баян-Өлгий	17	15	10	13
Говь-Алтай	35	3	9	27
Завхан	5	4	5	10
Увс	1	2	1	1
Ховд	62	42	43	39
Хангайн бүс	503	329	257	303
Архангай	5	1	-	1
Баянхонгор	14	8	4	6
Булган	1	1	2	12
Орхон	478	286	245	279
Өвөрхангай	3	31	4	2
Хөвсгөл	2	2	2	3
Төвийн бүс	1 077	1 144	1 487	1 307
Говьсүмбэр	10	3	3	3
Дархан-Уул	54	65	122	48
Дорноговь	243	212	106	120
Дундговь	11	3	6	9
Өмнөговь	615	794	1 190	1 063
Сэлэнгэ	17	16	9	6
Төв	127	51	51	58
Зүүн бүс	1 272	909	695	793
Дорнод	1 083	843	622	706
Сүхбаатар	134	53	54	66
Хэнтий	55	13	19	21
Улаанбаатар	2 966	2 255	1 995	2 108
УЛСЫН ДҮН	5 938	4 703	4 502	4 601

Зураг 4.4. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, оны эцэст, бүс, хувиар



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 2.6 (54.6%) мянга нь дипломын болон бакалаврын дээд, 1.4 (30.6%) мянга нь техникийн болон мэргэжлийн, 0.3 (7.5%) мянга нь бүрэн дунд, 0.2 (4.3%) мянга нь тусгай мэргэжлийн дунд, 0.1 (3.0%) мянга нь суурь боловсролтой байна.

Ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийг ажил мэргэжлийн ангиллаар авч үзэхэд хамгийн их буюу 1.8 (40.2%) мянга нь мэргэжилтэн, хамгийн бага буюу 3 (0.07%) иргэн хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан байна. Байгууллагын хариуцлагын хэлбэрээр нь авч үзэхэд хязгаарлагдмал хариуцлагатай компанид 3.3 (70.8%) мянга нь, 1 (0.02%) иргэн нөхөрлөлд ажиллаж байна.



5. ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААН

Хөдөлмөрийн хамтын маргаан 2019



Хамтын маргаан
2 тохиолдол

Боловсролын салбарт



Хамтын маргаан 1
Хамтын маргаанд хамрагдсан
ажиллагчид 32

Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа



Хамтын маргаан 1
Хамтын маргаанд хамрагдсан
ажиллагчид 77


Хамрагдсан ажиллагчдын
тоо 109



5.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, ДАВТАМЖ, УРСГАЛ

Хөдөлмөрийн хамтын маргааны тоо мэдээллийг аж ахуйн нэгж, байгууллагууд аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамж, үйлчилгээний хэлтэст, ХХҮХэлтэс нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд, ХНХяам нь Үндэсний статистикийн хороонд ирүүлж ҮСХ-ноос албан ёсны статистик болон тархагдаж байна.

Мэдээллийн урсгалын схем



5.2. ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААНЫ СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хөдөлмөрийн хамтын маргаан 2019 онд 2 бүртгэгдэж өмнөх оноос 88 (97.8%)-аар буурсан байна. Харин нийт хөдөлмөрийн маргаанд хамрагдсан ажиллагчид өмнөх оноос 6266 (98.3%)-аар буурсан байна.

Хүснэгт 5.1. Хөдөлмөрийн хамтын маргаан

Үзүүлэлт	2017	2018	2019
Хамтын маргааны тоо	239	90	2
Хамрагдсан ажиллагчид	5 924	6 375	109
Ажлын нэг өдөр түүнээс дээш хугацаатай ажил хаялт	5 717	5 007	-
Ажлын байр түр хаалт	3	-	-
Бусад хэлбэр	204	47	-
1000 ажиллагчид ногдох хамрагдсан ажиллагчид	4.8	5.1	0.1

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

2019 оны байдлаар хөдөлмөрийн маргаанд хамрагдагчдын 77 (70.6%) нь Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа салбарын, 32 (29.4%) нь боловсролын салбарын ажиллагчид байна.

Хүснэгт 5.2. Хөдөлмөрийн хамтын маргаанд хамрагдагчид, салбараар

Үйл ажиллагааны чиглэл	2017		2018		2019	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	126	80	-	-	-	-
Уул уурхай, олборлолт	238	11	-	-	-	-
Боловсруулах үйлдвэрлэл	-	-	139	80	-	-
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	-	-	-	-	-	-
Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	-	-	-	-	77	24
Боловсрол	6210	4854	6236	5157	32	26
УЛСЫН ДҮН	6574	4945	6375	5237	109	50

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам


Хүснэгт 5.3. Хөдөлмөрийн хамтын маргаанд хамрагдсан ажиллагчид, аймаг нийслэлээр

Аймаг, нийслэл, бүс	2017		2018		2019	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Баруун бүс	-	-	-	-	-	-
Хангайн бүс	1131	779	1533	1182	77	24
Архангай	-	-	-	-	77	24
Баянхонгор	775	534	-	-	-	-
Булган	110	86	-	-	-	-
Орхон	-	-	1533	1182	-	-
Өвөрхангай	246	159	-	-	-	-
Хөвсгөл	-	-	-	-	-	-
Төвийн бүс	377	342	1123	984	-	-
Говьсүмбэр	-	-	-	-	-	-
Дархан-Уул	273	256	284	261	-	-
Дорноговь	-	-	581	491	-	-
Дундговь	-	-	-	-	-	-
Өмнөговь	-	-	-	-	-	-
Сэлэнгэ	104	86	258	232	-	-
Төв	-	-	-	-	-	-
Зүүн бүс	1134	661	327	231	32	26
Дорнод	-	-	-	-	-	-
Сүхбаатар	1134	661	327	231	32	26
Хэнтий	-	-	-	-	-	-
Улаанбаатар	3932	3163	3392	2840	-	-
УЛСЫН ДҮН	6574	4945	6375	5237	109	50

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Хөдөлмөрийн хамтын маргаанд 2019 онд нийт 109 ажиллагчид хамрагдсаныг аймгаар авч үзвэл 77 буюу 70.6% нь Архангай, 32 буюу 29.4% нь Сүхбаатар аймаг байна. Харин 2018 онд хамтын маргаанд 6375 ажиллагчид хамрагдсан нь өмнөх оноос 199 буюу 3.2 хувиар буурсан байна.

Зураг 5.1. Хөдөлмөрийн хамтын маргаан, шийдэгдсэн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам


2017 онд нийт 239 хөдөлмөрийн хамтын маргаан бүртгэгдсэнийг шийдвэрлэсэн байдлаар нь үзвэл 238 буюу 99.6%-ийг шийдвэрлэсэн бол 2018 онд 90 хамтын маргаан бүртгэгдсэнээс 89 буюу 98.9%-ыг шийдвэрлэсэн байна. Харин 2019 онд 2 хамтын маргаан бүртгэгдсэнээс 100% шийдвэрлэсэн байна.



6. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО



Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого 2019



6.1. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ

Үндэсний статистикийн хороо нь Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэдээллийн эх үүсвэрээс улирлын давтамжтайгаар албан ёсны статистик болгон тархааж байна.

Анхан шатны бүртгэл нь, ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тухай бүр “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэлийн маягт”-ын дагуу мэдээллийг бүртгэж тухайн орон нутгийн мэргэжлийн хяналтын газарт ажлын 3 хоногийн дотор хүргүүлж, орон нутгийн мэргэжлийн хяналтын газар ажил олгогчоос ирүүлсэн мэдээллийг нэгтгэн www.om.inspection.gov.mn сайтад мэдээллийг шивж онлайнаар МХЕГ-т дамжуулснаар бүрддэг.

Судлан
бүртгэх
дүрэм

“Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 29-ны 269 дугаар тогтоолоор баталсан бөгөөд хуучин дүрмийн хавсралт болох “Үйлдвэрлэлийн ослын хагас, бүтэн жилийн тайлангийн маягт”-ыг албан ёсны болон захиргааны статистик мэдээ, тайлангийн маягт болгон, мөрдүүлэх шийдвэрийг гаргасан.

Маягт,
заавар

ҮСХ нь Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын статистикийг бий болгох үүднээс 2015 оны 11 дүгээр сарын 24-ны А/134 тоот тушаалаар мэдээллийн маягт, зааврыг батлан 2016 оноос мөрдөж эхлээд байгаа.

Аргачлал,
арга зүй

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 12 дугаар сарын 24-ны А/185 тоот тушаалаар батлагдсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос шалтгаалсан гэмтлийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал"-ыг үндсэн аргачлал болгон мөрдөнө.

Мэдээллийн урсгалын схем



6.2. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол 2019 онд 336 бүртгэгдсэнээс 324 (96.4%) нь үйлдвэрлэлийн осол, 12 (3.6%) нь хурц хордлого байна.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 2019 онд Улаанбаатар хотод 124 (36.9%), төвийн бүсэд 93 (27.7%), өмнөговь аймагт 33 (9.8%) тус тус тохиолдсон байна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдлыг өмнөх жилтэй харьцуулахад 0.8 хувиар өсжээ.


Хүснэгт 6.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, аймаг, нийслэл, бүсээр

Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Аймаг, нийслэл	2016	2017	2018	2019
Баруун бүс	30	28	31	29
Баян-Өлгий	8	4	4	4
Говь-Алтай	5	3	7	13
Завхан	11	7	4	6
Увс	3	4	-	3
Ховд	3	10	16	3
Хангайн бүс	43	24	30	39
Архангай	3	5	6	3
Баянхонгор	10	1	4	11
Булган	2	1	4	2
Орхон	20	11	15	19
Өвөрхангай	4	3	1	3
Хөвсгөл	4	3	-	1
Төвийн бүс	70	105	86	93
Говьсүмбэр	5	6	6	6
Дархан-Уул	21	48	14	10
Дорноговь	3	2	8	16
Дундговь	3	3	3	4
Өмнөговь	15	26	23	33
Сэлэнгэ	12	10	16	11
Төв	11	10	16	13
Зүүн бүс	30	27	34	35
Дорнод	6	5	17	13
Сүхбаатар	6	6	1	5
Хэнтий	18	16	16	17
Улаанбаатар	146	135	94	124
Бусад	13	13	8	16
УЛСЫН ДҮН	332	332	283	336

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол 2019 онд 248 (73.8%) нь эрэгтэй ажиллагч 88 (26.1%) нь эмэгтэй ажиллагч байна. Үйлдвэрлэлийн осолд 2016-2019 оны дунджаар 892 (69.5%) нь эрэгтэй ажиллагчид, 391 (30.4%) нь эмэгтэй ажиллагчид тус тус өртсөн байна.


Зураг 6.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, хүйсээр



Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Осолдогчдыг насны бүлгээр авч үзвэл 2019 онд 14 хүртлэх насанд 3 (0.9%), 15-17 насанд 3 (0.9%), 18-24 насанд 47 (14.0%), 25-34 насанд 133 (33.6%), 35-44 насанд 94 (28.0%), 45-59 насанд 75 (22.3%), 60 дээш насанд 1 (0.3%) байна.

Зураг 6.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, насны бүлгээр, 2016-2019 он



Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Үйлдвэрлэлийн осолдогчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар авч үзвэл 2019 онд уул уурхай, олборлолтын салбарт улсын дүнгээр 80 (23.8%), эрэгтэй ажиллагсад 78 (97.5%), эмэгтэй ажиллагсад 2 (0.3%) байна. Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа салбарт улсын дүн 16 (4.8%), эрэгтэй ажиллагсад 1 (6.2%), эмэгтэй ажиллагсад 15 (93.8%) байна.


Хүснэгт 6.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар

Салбар	2016		2017		2018		2019	
	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	5	1	2	-	6	1	3	-
Уул уурхай, олборлолт	61	9	55	4	73	7	80	2
Боловсруулах үйлдвэрлэл	32	6	62	9	26	12	24	4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	19	5	5	2	7	-	12	-
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	5	-	11	3	9	3	23	3
Барилга	21	2	15	3	17	1	38	5
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	8	1	5	2	7	2	8	2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	19	3	21	5	27	2	39	8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	5	4	4	2	4	2	11	7
Мэдээлэл, холбоо	8	3	4	2	3	-	5	1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	7	5	13	9	7	5	10	3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	-	-	-	-	-	-	-	-
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	-	-	2	-	-	-	3	2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3	-	2	1	4	2	-	-
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	43	18	36	9	34	15	22	9
Боловсрол	33	18	32	20	16	7	14	13
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	36	26	35	24	25	20	16	15
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1	1	1	-	1	1	1	-
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	23	10	24	8	15	2	27	14
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	-	-	1	1	1	-	-	-
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	3	3	2	1	1	1	-	-
УЛСЫН ДҮН	332	115	332	105	283	83	336	88

Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Осолдогчдыг эрхэлж байсан ажил мэргэжлээр авч үзвэл 2019 онд энгийн ажил мэргэжилтэй 142 (42.3%), үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан 51 (15.2%), суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч 45 (13.4%), мэргэжилтэн 30 (8.9%), техникч болон туслах, дэд мэргэжилтэн 26 (7.7%), контор, үйлчилгээний ажилтан 16 (4.8%), зэвсэгт хүчний ажил, мэргэжил 9 (2.7%), худалдаа, үйлчилгээний ажилтан 9 (2.7%), менежер 8 (38.8%) тус тус эзэлж байна.


Зураг 6.3. Осолдогчид, ажил мэргэжлээр, 2019



Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан шалтгааныг авч үзэхэд 2019 онд голчлон унаж, бүдэрсэн, хальтисан болон эд зүйлд хавчуулагдсан зэрэг байна.

Зураг 6.4. Осолдогчид, осолд орсон шалтгаанаар, 2019



Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас 2019 онд 138 (41.1%) хөнгөн хэлбэрээр, 146 (43.5%) хүнд хэлбэрээр гэмтэж, 52 (15.5%) хүн нас барсан байна.


Хүснэгт 6.3. Үйлдвэрлэлийн осол орсон хүний тоо салбарын ангилаар, хөнгөн, хүнд зэргээр

Салбар	Хөнгөн				Хүнд			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1	1	3	1	3	1	2	2
Уул уурхай, олборлолт	21	24	30	27	37	24	31	34
Боловсруулах үйлдвэрлэл	8	10	12	7	20	48	13	13
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	7	2	2	6	10	3	2	3
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1	7	2	4	3	4	6	12
Барилга	7	2	1	10	7	7	12	19
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	3	2	1	5	5	3	5	3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	12	10	12	25	5	8	12	12
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2	1	3	9	3	3	1	2
Мэдээлэл, холбоо	4	1	1	3	3	3	2	1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	5	8	3	3	2	4	4	7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	-	-	-	-	-	-	-	-
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	-	-	-	1	-	1	-	2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1	1	1	-	2	1	3	-
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	17	12	13	8	19	22	18	11
Боловсрол	19	10	4	5	14	22	11	8
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	20	17	10	9	15	18	15	7
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1	-	-	1	-	1	1	-
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	12	11	7	14	9	11	8	10
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	-	-	-	-	-	-	1	-
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1	1	1	-	2	1	-	-
УЛСЫН ДҮН	142	120	106	138	159	185	147	146

Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Үйлдвэрлэлийн ослоор 2019 онд 100.000 хүн ам тутмын 4 нь нас барж, 24 нь хөнгөн болон хүндээр гэмтсэн байна.

Зураг 6.5. Ажлын байр дахь хүнд болон хөнгөн осол гэмтлийн давтамжийн хувь (100.000 ажилтан бүрт)



Эх үүсвэр: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар